





**Мөнгөн хөрөнгийн удирдлагын журамд
өөрчлөлт оруулах тухай**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.13 дахь заалт, 80 дугаар зүйл, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.5 болон 9.6.17 дахь заалт, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”)-ийн 2026 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн эчнээ санал хураалтын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компани нь мөнгөн хөрөнгийг зохистой, үр ашигтай удирдаж, мөнгөн хөрөнгийн ашигт байдлыг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд Компанийн ТУЗ-ийн 2026 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 26/08 тоот тогтоолоор батлагдсан “Мөнгөн хөрөнгийн удирдлагын журам”-д өөрчлөлт оруулахаар шийдвэрлэсүгэй.
2. Энэхүү тогтоолын 1-т заасны дагуу өөрчлөлт орж буй “Мөнгөн хөрөнгийн удирдлагын журам”-ыг энэхүү тогтоолын Хавсралт №1-ээр баталсугай.
3. Энэхүү тогтоолын Хавсралт №1-ээр батлагдсан Компанийн “Мөнгөн хөрөнгийн удирдлагын журам”-ыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх, дагаж мөрдөхийг Компанийн эрх бүхий албан тушаалтнуудад үүрэг болгосугай.
3. Энэхүү Журмын өөрчлөлттэй холбогдуулан Компанийн үйл ажиллагаанд мөрдөгдөх холбогдох бусад бодлого, дүрэм, журам, зааврыг түүнд нийцүүлэн боловсруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах, шаардлагатай тохиолдолд өөрчлөлтийн саналыг Компанийн ТУЗ-д танилцуулж, шийдвэрлүүлэхийг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д даалгасугай.
4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Компанийн ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга (Х.Хулан)-д үүрэг болгосугай.

ТУЗ-ИЙН ГИШҮҮД:

		
/О.БОЛДБААТАР/		/Ц.ТҮМЭНЦОГТ/
		
/КАЦУХИКО МАДОНО/		/Х.БАТСҮРЭН/
		
/Д.ОТГОНБАЯР/		/С.НЭРГҮЙ/
		
/С.ЭНХ-АМГАЛАН/		/Б.ХОС-ЭРДЭНЭ/
		
/Ц.УУГАНБАЯР/		